



ОРХОН АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2021 оны 05 сарын 20-ны өдөр

Дугаар А/54

Эрдэнэт

“Хөрөнгө гаргах тухай”

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Улсын Онцгой комиссын 2021 оны 04 дүгээр тогтоол, Эрүүл мэндийн сайдын 2021 оны “Бүх нийтийн бэлэн байдлын зэргийг сунгах тухай” А/24 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Коронавируст халдвар /Ковид-19/-ын халдварыг илрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлэх зорилгоор эмч, эмнэлгийн мэргэжилтнийг чадавхижуулах сургалтын удирдамжийг хавсралтаар баталсугай.

2. Сургалтын үйл ажиллагааг удирдамжийн дагуу зохион байгуулж ажиллахыг Яаралтай, гамшгийн үеийн тусламж үйлчилгээ, оношилгоо эмчилгээний технологи хариуцсан мэргэжилтэн /Б.Уртнасан/-д үүрэг болгосугай.

3. Шаардлагатай 114.500 /нэг зуун арван дөрвөн мянга таван зуун мянган төгрөг/-ийг төсөл хөтөлбөрийн зардлаас гаргахыг Салбарын санхүү бүртгэл мэдээлэл, нягтлан бодохын ажилтан /Н.Чулуун-Эрдэнэ/-д зөвшөөрсүгэй.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт шинжилгээ үнэлгээ дотоод аудит хариуцсан мэргэжилтэн /Г.Энхжаргал/-д даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР  
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Д.СҮХЭЭ

БАТЛАВ.  
ЭМГ-ЫН ДАРГЫН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Д.СҮХЭЭ

**ЭМЧ, ЭМНЭЛГИЙН МЭРГЭЖИЛТНИЙГ ЧАДАВХЖУУЛАХ СУРГАЛТЫН УДИРДАМЖ**

Орхон аймаг

2021.04.25

**ЗОРИЛГО:** Коронавируст халдварыг илрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлэх зорилгоор ЭМГ-ын НЭМТ-ийн байранд шинээр ашиглалтанд орох вируслогийн лабораторт багаж тоног төхөөрөмжийг суурилуулах, нийлүүлэгч компаниас лабораторит ажиллах эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдэд сургалт хийх, дадлагажуулах

**СУРГАЛТЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ:** 2021 оны 04-р сарын 26-27-ны хооронд ЭМГ-ын НЭМТ-ийн вируслогийн лабораторт хийгдэнэ. Сургалтанд ЭМГ-аас-2 мэргэжилтэн, АНТИ-ГЕН ХХК-8 ажилтан, БОЭТ-оос -7 лабораторийн их эмч, лаборант, Медипас төрөлжсөн төв эмнэлгийн 2-микробиологч, лаборант нар хамрагдана.

**СУРГАЛТЫН ҮР ДҮН:**

- Орхон аймагт Коронавируст халдварын оношилгооны хүчин чадал нэмэгдэж, ПГУ шинжилгээний тоо нэмэгдснээр халдварыг эрт илрүүлэх
- Вируслогийн лабораторт ажиллах эмч, лаборант нар шинээр суурилуулсан аппаратыг ажиллуулах чадварыг эзэмшсэн байна
- Ойрын болон дам хавьтлуудын ПГУ шинжилгээ хийгдэнэ

**ШААРДЛАГАТАЙ САНХҮҮЖИЛТ:**

№	Нэр төрөл	тоо	Ширхэг	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	Кофе	20 хүн 2 удаа	40	600	24,000
2	Кекс	20 хүн 2 удаа	40	1500	60,000
3	Нэг удаагийн аяга	25х2	50	4500	4500
4	Ус	20х2	40	650	26,000
<b>Нийт</b>					<b>114,500</b>

УДИРДАМЖ БОЛОВСРУУЛСАН: ЯГУТҮХМЭРГЭЖИЛТЭН *Б.Уртнасан* Б.УРТНАСАН  
САНХҮҮГИЙН ТООЦООЛОЛ ХИЙСЭН: ЭДИЙН ЗАСАГЧ *Д.Отгондэлгэр* Д.ОТГОНДЭЛГЭР